



БОЛОВСРОЛЫН
ЯАМ



ЭРҮҮЛ МЭНДИЙН
ЯАМ



ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ



From
the People of Japan



Save the
Children

“ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ, ТОГТВОРТОЙ, ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСӨЛ (2025-2026)

МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС № 1

2025 оны 7-р сар



Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Игавахара Масару “Ачлахуй” өрхийн эрүүл мэндийн төвд зочлох үеэр, 2025 оны 4-р сарын 9.

ТУРШЛАГА СОЛИЛЦОХ УУЛЗАЛТ

2025 оны 3-р сар

Хүүхдийг Ивээх Сан төслийн туршлага солилцох уулзалтыг 2025 оны 3-р сарын 21-ний өдөр Улаанбаатар хотод зохион байгууллаа. Уулзалтын зорилго нь төслийн эхний жилийн үр дүнг танилцуулах, төсөлд оролцогч талууд харилцан туршлагаа хуваалцах, ирэх оны үйл ажиллагааны талаар санал солилцоход оршиж байв.



Жил бүр зохион байгуулагддаг энэхүү уулзалтад төслийн зорилтот цэцэрлэг, Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Боловсролын яам, Эрүүл мэндийн яам, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, орон нутгийн Засаг даргын тамгын газар болон боловсрол, эрүүл мэндийн газар, салбар комисс, төрийн бус байгууллагын төлөөлөл зэрэг 45 гаруй хүн оролцлоо.

Уулзалтын үеэр зорилтот цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төв, орон нутгийн салбар комиссын төлөөллүүд төслийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын сайн туршлага, хуримтлуулсан сургамжаа оролцогчдод танилцууллаа. Мөн дээрх гурван яамны төлөөлөл илтгэл тавьж, бага насны хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын талаар тус тусын салбартаа баримталж буй бодлогын талаар танилцуулж, төслийн үр дүнг онцолж дурдлаа. Тухайлбал, Боловсролын яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар “Тусгай хэрэгцээтэй хүүхдэд туслалцаа үзүүлэх цэцэрлэгийн дэмжлэгийн багийн чадавхыг цаашид бэхжүүлэх, багш нарын арга зүйг дээшлүүлэх, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын салбартай бодлогоо уялдуулан ажиллах зорилт тавин ажиллаж байна. Зорилгодоо хүрэхэд энэ төсөл маш их дэмжлэг болж байна.” хэмээн дурдлаа. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын

яамны Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэлтсийн дарга С.Рэгзэн “Энэхүү төслийн хүрээнд зорилтот аймаг, дүүргийн салбар комиссын гишүүдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлснээр тэдний ажлын ур чадвар дээшилж, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй видео контентууд олон нийтэд амжилттай хүрч байна. Цаашид салбар комиссын бүх гишүүдийг чадавхжуулах, холбогдох бодлогын баримт бичгүүдийг шинэчлэх зорилт тавин ажиллаж байна” хэмээн онцлов.

Эрүүл мэндийн яамны мэргэжилтэн Б.Пүрэвжав “Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг боловч бага насны хүүхдийн эрүүл мэндийн талаарх эцэг эхчүүдэд зориулсан сургалт, зөвлөгөө дутмаг байгааг дурдаад энэ чиглэлээр уг төсөл бидэнтэй хамтран ажиллаж байна” гэж цохон тэмдэглэлээ.



Япон улсын ЭСЯ-ны Хоёрдугаар нарийн бичгийн дараа Такаши Үмэда нээлтийн үг хэлж байна. Холидэй Инн Зочид буудлын хурлын танхим, 2025 оны 3-р сарын 21



Төслийн менежер Эри Номото Сэлэнгэ аймгийн салбарын комисст техник хэрэгсэл гардуулж байна. Холидэй Инн Зочид буудлын хурлын танхим, 2025 оны 3-р сарын 21



Уулзалтад оролцогчид, Холидэй Инн Зочид буудлын хурлын танхим, 2025 оны 3-р сарын 21



Уулзалтад оролцогчид, Холидэй Инн Зочид буудлын хурлын танхим, 2025 оны 3-р сарын 21

ЯПОН УЛСЫН ЭЛЧИН САЙД НОЁН ИГАВАХАРА МАСАРУГИЙН ТӨСЛИЙН ЗОРИЛТОТ БАЙГУУЛЛАГУУДАД ХИЙСЭН АЙЛЧЛАЛ

2025 оны 4-р сар

2025 оны 4-р сарын 9-нд Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Игавахара Масару төсөл хэрэгжиж буй Нийслэлийн Баянзүрх дүүргийн 32-р цэцэрлэг, “Ачлахуй” Өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаатай танилцаж, төслийн үр дүнтэй танилцлаа. Элчин сайдын айлчлалын үеэр 32-р цэцэрлэгийн эрхлэгч Д.Лхагвасүрэн тус төслийн хэрэгжилт, гарч байгаа үр дүнг зочдод танилцуулав.



Элчин сайд “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим”-тай танилцаж байна. 32 дугаар цэцэрлэг, 2025 оны 4-р сарын 9.

Төсөл тус цэцэрлэгт хэрэгжиж эхэлснээр багш, ажилтнууд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйд суралцаж, мэдлэг чадвараа нэмэгдүүлэн ажиллаж байна. Төслийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг сурч, хөгжихөд зориулан “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим”-ыг холбогдох тавилга, ном, сургалтын хэрэглэгдэхүүний хамт иж бүрнээр нь байгуулж, налуу зам, туслах хэрэгсэл, ариун цэврийн өрөөний тохижилт зэрэг дэд бүтцийн засварын ажлууд хийсэн байна. Энэ бүхний үр дүнд хөгжлийн бэрхшээлтэй найман хүүхэд ердийн цэцэрлэгийн орчинд бусад хүүхдүүдийн хамт сурч, хүмүүжиж байна.

Мөн Элчин сайд Баянзүрх дүүргийн 8-р хорооны иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг “Ачлахуй” өрхийн эрүүл мэндийн төвд зочилсон. Төслийн хүрээнд тус төвийн эмч, ажилтнуудыг бага насны хүүхдийн эрт илрүүлэг, хөгжлийн дэмжлэг үзүүлэх арга зүйн сургалтуудад хамруулж, хүүхдийн

өсөлт хөгжлийн үнэлгээ, эрүүл мэндийн үзлэг хийх өрөөг шинээр тохижуулжээ.



Төсөл эхэлснээс хойш бага насны хүүхдийн эрүүл мэндийн үзлэг, хөгжлийн үнэлгээнд 9, 18, 36 сартай 157 хүүхдийг хамруулснаар хоол тэжээлийн цочмог дутагдалтай 6, өсөлт болон хэл ярианы хоцрогдолтой 13 хүүхдийг илрүүлсэн байна.

Хүүхдүүд бага насандаа эрт оношлогдож, хугацаа алдахгүй дараагийн шатны эмчилгээнд хамрагдсанаар хожим гарах хүндрэлээс сэргийлэх боломж бүрджээ.

Элчин сайд эдгээр байгууллагын хамт олонд халуун талархал илэрхийлж, цаашдын ажилд нь амжилт хүслээ.



Элчин сайд хүүхдийн үзлэгийн өрөөтэй танилцаж байна. “Ачлахуй” ӨЭМТ, 2025 оны 4-р сарын 9.

“ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ, ТОГТВОРТОЙ, ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭГЭЭР БАГА НАСНЫ ХҮҮХДИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ НЬ” ТӨСЛИЙГ ТАНИЛЦУУЛАХ НЭЭЛТИЙН СЕМИНАР

2025 оны 4-р сар

“Тэгш хүртээмжтэй, тогтвортой, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийг 2 дах жилийн зорилтот байгууллагуудад танилцуулах нээлтийн семинар 2024 оны 4-р сарын 24-нд Монгол-Японы төвийн хурлын танхимд боллоо.


Уулзалтад Улаанбаатар хотын зорилтот гурван дүүргийн 320, 81, 83 дугаар цэцэрлэгүүд, “Нэмүүлэн”, “Анан”, “Мэнд-Аривжих” Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн удирдах ажилтнууд, багш эмч, дүүргийн засаг даргын тамгын газрын төлөөллүүд оролцлоо.

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч Л.Баян-Алтай уулзалтыг нээж хэлсэн үгэндээ “Та бүхэн манай төслийн багийнхантай ирэх 2 жилд үр бүтээлтэй хамтран ажиллахыг хүсэж байна” хэмээн онцлов. Төслийн багийн зүгээс төслийн зорилт, хэрэгжүүлэх үйл ажиллагаа, харилцан ойлголцлын санамж бичгийн агуулгыг уулзалтад оролцогчдод танилцууллаа.

Уулзалтын төгсгөлд Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч Л.Баян-Алтай зорилтот Өрхийн эрүүл мэндийн төв, цэцэрлэгүүдийн удирдах ажилтнуудтай хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурж, төслийн хүрээнд цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагаа, харилцан хүлээх эрх, үүргээ тодорхойллоо.



Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч Л.Баян-Алтай, Чингэлтэй дүүргийн 83 дугаар цэцэрлэгийн эрхлэгч Т.Сэлэнгэ нар хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурж байна. Монгол-Японы төвийн уулзалтын танхим, 2025 оны 4-р сарын 24



Уулзалтад оролцогчид. Монгол-Японы төвийн уулзалтын танхим, 2025 оны 4-р сарын 24

“МОНГОЛ ТАНАКА-БИНЕ” ОЮУН УХААНЫ СОРИЛ АВАГЧ БЭЛТГЭХ СУРГАЛТ

2025 оны 6-р сар

Нийт 5 өдрийн сургалт болсноос эхний 4 өдрийн сургалт 2025 оны 5-р сарын 27-30-ны өдрүүдийн хооронд Монгол Улсын боловсролын их сургуулийн Боловсрол судлалын сургууль дээр, сүүлийн 1 өдрийн сургалт 2025 оны 6-р сарын 18-ны өдөр Монгол Улсын боловсролын их сургуулийн төв байран дээр тус тус болов.



Сургалтанд Нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэг, Баянхонгор, Сэлэнгэ аймгийн зорилтот цэцэрлэг, ӨЭМТ, хамтрагч байгууллагуудын төлөөлөл болох нийт **17** хүн хамрагдлаа.



“Монгол Танака-Бине” оюун ухааны сорил авагч бэлтгэх сургалтанд оролцогчид багш нарын хамт.
МУБИС-ийн сургалтын танхим, 2025 оны 6-р сарын 18

Монгол Улсын боловсролын их сургуулийн 8 сургагч багш, Япон улсын Нагоягийн их сургуулийн сэтгэл зүйн хөгжил, судалгаа, дэмжлэгийн төвийн 4 мэргэжилтэн профессор хамтран “Монгол Танака-Бине” оюун ухааны сорил авагч бэлтгэх сургалтыг явууллаа.

Энэхүү сургалт нь оюун ухааны сорилын онолын үндэслэл, сорил авах арга зүй, оноожуулах, үр дүнг тайлбарлах зэрэг агуулгаар сорил авагч бэлтгэх зорилготой бөгөөд цаашид энэхүү сорилыг ашиглан өөрсдийн байгууллагуудад хүүхдийн оюун ухааны хөгжлийн түвшинг тодорхойлж, хүүхдийн хөгжлийг дэмжих юм. Онол дадлага хосолсон таван өдрийн сургалтаас бүрдэх бөгөөд сүүлийн нэг өдрийн сургалтаар дадлага ажлаа дүгнэлээ. Бүх оролцогч 5 өдөр буюу 40 цагийн сургалтаа дүүргэж, сорил авагчийн гэрчилгээ болон сорилын багц хэрэглэгдэхүүнийг хүлээн авлаа.



“Монгол Танака-Бине” оюун ухааны сорил авагч бэлтгэх сургалтанд оролцогчид, МУБИС-ийн сургалтын танхим, 2025 оны 5 сарын 29

Цаашид тус сургалтаар бэлтгэгдсэн сорил авагчид сорилын ач холбогдлын талаар байгууллагынхаа удирдлага болон бусад ажилтнуудад сайтар ойлгуулах, зорилтот насны хүүхдүүдээс сорил авах төлөвлөгөө гарган ажиллаж, 2026 оны 3-р сард сорил авсан тайлан мэдээг төслийн багт өгөхөөр боллоо.



МУБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн захирал Д.Мөнхжаргал сургалтыг нээж үг хэллээ. МУБИС-ийн сургалтын танхим, 2025 оны 5-р сарын 27

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ТӨСЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН УУЛЗАЛТ

2025 оны 5-р сар

2025 оны 5-р сарын 8-ны өдөр Сэлэнгэ аймагт хэрэгжиж буй “Тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих нь” төслийн удирдах зөвлөлийн ээлжит уулзалт Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын Хүндэтгэлийн танхимд боллоо.



Уулзалтад оролцогчид, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын хүндэтгэлийн танхим, 2025 оны 5-р сарын 8.

Уулзалтад Аймгийн Засаг даргын 2025 оны А/222 дугаар захирамжаар шинэчлэгдэн батлагдсан удирдах зөвлөлийн гишүүд, төлийн зорилтот байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн 16 гишүүн оролцлоо. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Эрүүл мэндийн газар, Боловсролын газар, Хүүхэд, Гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Хөгжлийн бэрхшээлтэй

иргэдийн холбооны дарга нар болон холбогдох мэргэжилтнүүд байдаг.

Хурлын үеэр зорилтот цэцэрлэг, ӨЭМТ, салбар комисс төслийн эхний жилийн хэрэгжилт, үр дүнг танилцуулж, цаашдын хамтын ажиллагааг бэхжүүлэх талаар болон ирэх жилийн үйл ажиллагааны төлөвлөлтийг хэлэлцэв.

ТӨСЛИЙН ЭХНИЙ ЖИЛИЙН ҮР ДҮНГ:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын нарийн бичиг Я.Ууганцэцэг,
- “Эмнэх баг” ӨЭМТ-ийн дарга Ц.Цэцэгсүрэн,
- Сүхбаатар сумын 3-р цэцэрлэгийн арга зүйч Н.Учрал нар тус тус дэлгэрэнгүй танилцууллаа.

Мөн төслийн зохицуулагч гурав дахь жилийн зорилтот байгууллагуудыг хэрхэн сонгох талаар оролцогчдын дунд хэлэлцүүлэг өрнүүлж, санал солилцов. Энэхүү уулзалт нь оролцогч талуудын

хамтын ажиллагааг улам бэхжүүлж, өргөжүүлэх, бага насны хүүхдийн цогц хөгжилд чиглэсэн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх чухал алхам боллоо.



Оролцогчид хэлэлцүүлэг хийж байна. Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын хүндэтгэлийн танхим, 2025 оны 5-р сарын 8.



ТӨСЛИЙН ЗОРИЛГО

Улаанбаатар хотын гурван дүүрэг, Сэлэнгэ болон Баянхонгор аймгийн зорилтот төрийн үйлчилгээний байгууллагуудад бага насны хүүхдийн хөгжлийг тэгш хүртээмжтэй, цогц үйлчилгээгээр дэмжих тогтолцоог бий болгоно.

✓ ТӨСЛИЙН ЗОРИЛТУУД

- 1 Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн тогтолцоог сайжруулах, чадавхыг бэхжүүлэх;
- 2 Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын чадавхыг бэхжүүлэх;
- 3 Цэцэрлэгийн чадавх, тогтолцоог бэхжүүлж, цэцэрлэгт хамрагдаж буй тусгай хэрэгцээтэй хүүхдийн ерөнхий боловсролын сургуульд шилжин суралцах үйл явцыг дэмжих;
- 4 Эцэг эхчүүд болон олон нийтэд чиглэсэн нөлөөллийн үйл ажиллагаа явуулах;
- 5 Засгийн газарт хандсан бодлогын нөлөөлөл, дэмжлэг үзүүлэх;

₮ ТӨСЛИЙГ САНХҮҮЖҮҮЛЭГЧ

Япон улсын Гадаад Хэргийн Яам

🕒 ТӨСЛИЙН ҮРГЭЛЖЛЭХ ХУГАЦАА

2025 оны 3-р сар - 2026 оны 3-р сар

🏠 ТӨСӨЛД ХАМРАГДАЖ БҮЙ БАЙГУУЛЛАГУУД

2024-2025 он

Аймаг/ дүүрэг	ӨЭМТ	Цэцэрлэг
Баянзүрх дүүрэг	“Ачлахуй” ӨЭМТ	32 дугаар цэцэрлэг
Сонгинохайрхан дүүрэг	“Ээлтэй” ӨЭМТ	117 дугаар цэцэрлэг
Чингэлтэй дүүрэг	“Энэрэнгүй үйлст ” ӨЭМТ	18 дугаар цэцэрлэг
Баянхонгор аймаг	“Энхбүрд” ӨЭМТ	16 дугаар цэцэрлэг
Сэлэнгэ аймаг	“Эмнэх баг” ӨЭМТ	6 дугаар цэцэрлэг

2025-2026 он

Аймаг/ дүүрэг	ӨЭМТ	Цэцэрлэг
Баянзүрх дүүрэг	“Нэмүүлэн” ӨЭМТ	320 дугаар цэцэрлэг
Сонгинохайрхан дүүрэг	“Анан” ӨЭМТ	81 дүгээр цэцэрлэг
Чингэлтэй дүүрэг	“Мэнд аривжих” ӨЭМТ	83 дугаар цэцэрлэг
Баянхонгор аймаг	“Оточ манал” ӨЭМТ	1 дүгээр цэцэрлэг
Сэлэнгэ аймаг	“Номт хан” ӨЭМТ	3 дугаар цэцэрлэг

ТӨСЛИЙН ҮР ШИМИЙГ ХҮРТЭГСЭД:

Шууд: 6,354 **Шууд бус:** 125,093



🏠 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Аризона төв, 4-р давхар
☎ +976-11-329365, +976-11-329371
📠 +976-11-329361

✉ secretary@savethechildren.mn
🌐 mongolia.secretary@savethechildren.org
📘 Save the Children in Mongolia
🐦 Save the Children MN